



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/35

Улаанбаатар хот

г

Ой, хээрийн түймрийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулах сургалт, дадлага зохион байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.2, 13.3.5, 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.2, 30.3, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Ойн тухай хуулийн 15 дугаар 15.1.2, Улсын Онцгой Комиссын 2019 оны “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний тухай” 01, нийслэлийн Онцгой комиссын 2019 оны “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний тухай” 02 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хан Хэнтийн тусгай хамгаалалтын газар нутаг бүхий нийслэлийн Налайх дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, арга ажиллагаанд сургах сургалт, дадлагыг 2019 оны 04 дүгээр сарын 15-17-ны өдрүүдэд зохион байгуулж явуулсугай.

2. Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх сургалтыг Налайх дүүргийн Онцгой комиссын гишүүд, Гамшгаас хамгаалах албад, Мэргэжлийн анги, Горхи, Тэрэлжийн байгалийн цогцолборт тусгай хамгаалалтын газрын сайн дурын бүлгэм, амралт, аялал жуулчлалын баазын захирал нар, аж ахуйн нэгж байгууллагын гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг, 1-7 дугаар хорооны иргэдийн сайн дурын хэсгийг хамруулан, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаагаар ханган удирдан зохион байгуулахыг Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтэс (дэд хурандаа Л.Чинбат)-т үүрэг болгосугай.

3. Сургалтад хамрагдах алба хаагчдын нэрсийг нэгдүгээр, шаардагдах зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Сургалт, дадлагад шаардагдах 4.854.858 (Дөрвөн сая найман зуун тавин дөрвөн мянга найман зуун тавин найман) төгрөгийг зохих зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.


5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга (дэд хурандаа Н.Нямхорлоо)-д даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА



Ж.ЧҮЛТЭМСҮРЭН

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн
А/35 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМРИЙН БЭЛТГЭЛ БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГУУЛАХ СУРГАЛТ,
ДАДЛАГАД ОРОЛЦОХ АЛБАН ХААГЧДЫН НЭРС

Д/д	Оролцох байгууллагууд	Оролцох алба хаагчдын тоо	Тайлбар
1	Нийслэлийн Онцгой байдлын газар	4	
2	Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтэс	16	
3	Онцгой комиссын ой, хээрийн түймэртэй тэмцэх ажлын хэсэг гишүүд	5	
4	Хороодын Засаг дарга нар	7	
5	Горхи, тэрэлжийн байгалийн цогцолборт тусгай хамгаалалтын газар	10	
6	Аялал жуулчлалын баазын захирал нар	10	
7	Аж ахуй нэгж байгууллагын сайн дурын хэсэг	10	
8	Иргэдийн сайн дурын хэсэг	10	
Нийт оролцох алба хаагчид		72	

---oOo---

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн
А/35 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМРИЙН БЭЛТГЭЛ БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГУУЛАХ
СУРГАЛТ, ДАДЛАГАД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зардлын нэр	Дүн	Тайлбар
1	Хүнс, хуурай хэрэглэл	1.960.512	
2	Шатахуун	1.529.246	
3	Бусад зардал	1.365.100	
Нийт дүн		4.854.858	

---oOo---